

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норжингийн Дашцэрэн	Дугаар	L327
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Хархорин сум, Шанх баг
Төрсөн газар	Хархорин сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шанхын хийд	Сүм хийдийн дугаар	ӨХХХ 016
Одоогийн сүм хийд	Шинэ Шанхны хийд	Сүм хийдийн дугаар	ӨХХХ 017
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 29	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанхын хүрээ, Шинэ Шанхын хийд

Норжингийн Дашцэрэн: За манай энэ Шанхын баруун хүрээг 1647 онд өндөр гэгээн Занабазар 13 настайдаа анх үндэслэн байгуулсан. Баруун хүрээ бол бүр анх Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Ширээ цагаан нуур гэдэг газар гэр дуганаа барьж цогчин айлдаж эхэлсэн гэдэг. Тэгээд янз бүрийн шалтгаан шаардлагаар нүүдэллэж явсаар энэ Шанхын Дулааны ар , Төгөл уулын ар ч гэдэг юм. Харзын гол, Сарын голын уулзвар Чөдөр голын эрэг дээр энэ Жаргалант уулын өвөр дээр төвхнөжээ. Домог хэлэхэд өндөр гэгээн Занабазар хүрээ хийдээ байгуулах гээд газар нутаг шинжиж явж байтал энэ хавьд цагаан морь унаж, цагаан газар хөтөлсөн хүнтэй уулзаж амар мэндээ мэдэж байтал морь нь үргэж ганзагалж явсан сүү тараг нь асгарчээ. Тэгээд хүний алдар нэгийг асуутал тэр хүн Бат гэдэг нэртэй хүн байж. Тэгээд өндөр гэгээн анхны дуганыхаа шавыг тавьж тэр Бат гэдэг хүний нэр дээр цагаан идээ асгарсны цагаан гэдэг үгийг оруулж Батцагаан гэж анхны дуганы байгуулжээ.Тэр нь энэ голын дуган. Энэ дуган хоёр давхар. 1000 гаруй лам багтаад хурчихдаг. Том дуган. Ингээд Шанхын хүрээ шав тавьсан цагаасаа эхлэн 7 дацан, 4 аймагтай 2000-аад ламтай хүрээ болон өргөжин тэлж 1937 он хүртэл байжээ.

Жужа: Ямар аймгуудтай байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норжингийн Дашцэрэн: Шадавлин, Даржаалин, Тойслин, Дашлин гэсэн 4 аймаг. 7 дацан нь цаньд, ламиран, зурхай, мамба, дүйнхор, жүд, авьдын дацан гээд ийм 7 дацан байсан.

Жужа: Та 4 аймаг, 7 дацан бас лам нарын болон борчуудын гэр хашааг энд энд байсан гээд бүдүүвчлэн зурж өгнө үү?

Норжингийн Дашцэрэн: За би та нарт ойлгуулахыг хичээж зуръя./ зурж өгөв бололтой/

Ингээд 1937 оныг хүртэл томоохон хүрээ хийд болж байгаад тухайн цаг үеийн байдлаас болж хаагдсан. Үүнээс хойш 53 жилийн дараа 1990 онд ахиж сэргээн хурал номоо эхлүүлсээр өнөөдрийг хүржээ. Манай хүрээ бол түүхэн уламжлал, бурхан тахил, ариун баялаг ном судартай хүрээ. 1937 онд хүрээ хийд хаагдахад тэнд шавилж байсан олон залуу лам нарыг хар болгож лам нарын артел гэж байгуулан одоо бол гар үрчуудын артел гэсэн үг юм даа. Тэгээд хүрээний бурхан тахил, элдэв зүйлийг тэнд шатааж устгах, эвдэх зэргээр өөр төрлийн бүтээгдэхүүн хийж байж. Тэгэхэд нь тэнд артелд ажиллаж байсан манай хүрээний лам нар болох Цэвээний Цэрэнпэл, Лувсандоржийн Нацаг, Гомбосүрэнгийн Найдан зэрэг лам нар яг тэр үедээ хар болчихсон хүмүүс ш дээ, хүрээнийхээ тэр бурхан тахилаас нууж хааж авч үлдэн устгуулж эвдүүлэлгүй авсан байгаа юм.

Жужа: 1990 онд анх нээгдэхэд хэдэн өвгөн лам байсан бэ?

Норжингийн Дашцэрэн: Яг хуралд ирж хүрсэн 20 гаруй өвгөн лам байсан. Цаана нь нас өндөр болсон эрүүл мэнд муу гээд хуралд орж чадаагүй олон настай лам нар байсан.

Жужа: Одоо хэдэн ламтай байна вэ?

Норжингийн Дашцэрэн: 5-6 ламтай. Эндээ л байнга байж хурал хүрж байдаг.

Жужа: Хуучин хүрээний гол сахиус нь юу вэ?

Норжингийн Дашцэрэн: Баруун хүрээний гол сахиус бол махгал, арван сахиусны хамгийн гол нь шүү дээ.

Жужа: Цам бүжиг гарч байх үү?

Норжингийн Дашцэрэн: Байхаар барах уу. Цам гарна, майдар эргэнэ. Хүрээгээ тойроод л 4 талд нь нэг нэг үдлээд л явна. Аа тэр үед нь цам гарч ирээд л өвгөн эмгэн хоёр нохойгоо хөтлөөд ч явж байх шиг, азар ч гараад ирсэн явж байх шиг

Жужа: Майдар хэзээ эргэдэг байсан бэ?

Норжингийн Дашцэрэн: Одоо манайх зуны эхэн сарын шинийн 3-нд эргэж байгаа. Хуучин хүрээ бол би бага байсан, яг он сараар нь мэдэхгүй байна. Хаврын эхэн сард л болов уу. Дулаарчихсан, цас хайлаад л багачууд майдар эргэх үеэр хөл нүцгэн л гүйж байсан юм даг. Одоогийн хаврын эхэн сар ч хаврын эхэн сар биш болж дээ. Одоо ч байгаль өөр болж дээ.

Жужа: Хайлан хүрж байсан үү?

Норжингийн Дашцэрэн: Хайлан хуралгүй дээ.

Жужа: Аль дугандаа хүрж байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норжингийн Дашцэрэн: Цогчиндоо ч хурна. Цаньд дээрээ л голлож байж.

Жужа:Цаньд хэдэн ламтай байсан бэ?

Норжингийн Дашцэрэн: Аа мэдэхгүй, тэр олон юмыг.

Жужа: Та аль аймагт сууж байв?

Норжингийн Дашцэрэн: Шадавлин.

Жужа: Шадавлингийн гол шүтээн юу вэ?

Норжингийн Дашцэрэн: Жамсран.

Жужа: Зоч лам нар байсан уу?

Норжингийн Дашцэрэн: Тэр цөөн.Хүрээн дотор байхгүй. Хүрээний гадна сууна. Тэр олон лам нарын дэргэд гурав дөрвөн зоч л байх.Хайдав зоч, Чойндон зоч, нэг эмэгтэй зоч байсан юм. Бөгтөр Дулмаа гэж.

Жужа: Чойжин бууж байсан уу?

Норжингийн Дашцэрэн: Аа мэдэхгүй мэдэхгүй. Тийм юм байхгүй байсан байх. Энэ зууд л чойжин бууж байна гэж сонссон.

Энхбаяр: Танай хүрээний гол урсгал юу байв, гэлүгба биз дээ, улааных уу?

Норжингийн Дашцэрэн: Үгүй ээ, үгүй шарын шашны, шарын л чиглэл.

Жужа: Дугануудыг юугаар хийсэн байсан бэ?

Норжингийн Дашцэрэн: Дандаа хөх тоосгон ханатай.Дээд тал нь модон материалтай.

Жужа: Суваргууд хэр олонтой байсан бэ?

Норжингийн Дашцэрэн: Тэр овоо хэдэн суварга байсан. Ер нь 1937 онд хүрээ хаагдаж1939 онд энд сум төвлөрсөн юм. Тэгээд сумын төв энэ хүрээний үлдэгдэл хэдэн суварга, хэрэм, энэ гол дуган тэргүүтэй хоёр гурван дуганыг бараадаж байгуулагдсан учир хэрэм дугануудыг бүрэн бүтнээр нь авч үлджээ. Ухаандаа тэр бэлэн дугануудыг ашиглаж сумын хоршоо одоо энэ Батцагаан гол дуганд малын түүхий эд, арьс ширний агуулах хийж байсан байх жишээтэй. Бэлэн материаллаг бааз дээр түшиглэж байгаа ухаантай. Иймдээ энэ дугануудын бүрэн бүтэн байдал гайгүй үлдэж 1990 онд баруун хүрээг шинээр сэргээхэд их нэмэр болсон.

Жужа: Хүрээнд Төвдөөс лам нар ирж байсан уу?

Норжингийн Дашцэрэн: Мэдэхгүй, үгүй байх. Манайхаас төвд рүү явж сурч байснаас ирж байхыг нь мэдэхгүй юм.

Жужа: Та хэдэн настай лам болсон бэ?

Норжингийн Дашцэрэн: 6 настай лам болсон. 12, 13 хүрээд хөдөөлсөн.

Жужа: Та хэдэн онд төрсөн?

Норжингийн Дашцэрэн: 1925 онд төрсөн.

Жужа: Таны багад баруун хүрээнд хятадууд байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норжингийн Дашцэрэн: Өө байсан. Хятадын пүүс мұхлагууд ойролцоо зөндөө л байсан.

Жужа: Баруун хүрээ хэр олон жастай байсан ?

Норжингийн Дашцэрэн: Аймаг бүр жастай, бас төв жас гэж байна. Сангай гэж нэрлэдэг юм.

Жужа: Баруун хүрээнд олон хутагт хувилгаад төрсөн үү?

Норжингийн Дашцэрэн: Өө олон байсан байх. Эрдэм чадалтай лам нар. Ер нь хамгийн олон аграмбатай нь баруун хүрээ юм гэнэ лээ. 72, 73 аграмма байсан гэж С.Ичиноровын “ Сүүдэр дарсан он жилүүд” гэдэг номонд бичсэн байгаа.

Жужа: Гавжийн дамжаа барьж байсан үү?

Норжингийн Дашцэрэн: Барилгүй яахав. Чойрын номны арван анги зиндааг дуусгасан хүмүүс гавжийн дамжаа барина.

Жужа: Аграмбын дамжаа барьж байсан үү?

Норжингийн Дашцэрэн: Тэрнийг бол үгүй. Богдын хүрээ явж л аграмма барьж байсан гэдэг.

Жужа: Та гучин долоон оноос хар болоод юу юу хийв?

Норжингийн Дашцэрэн: Хар болоод хөдөө гарч мал малласан. Өвөг эцэг нь өвчтэй хөөрхөн хэдэн малтай. Дүүтэйгээ ээжийгээ харна. 14, 15 настайдаа өрх гэрээ толгойлсон. Надад хийгээгүй ажил бараг байхгүй. Аян жин тээж , арьс нэхий хүртэл элдэж үзлээ. Монгол хүний хийх бүх л ажлыг хийсэн л дээ. 1945 онд цэрэгт явж хязгаарын цэрэгт 5 жил алба хаасан. 1949 оноос төрийн захиргааны албанд 42 жил ажиллаж сум нэгдлийн орлогч, жинхэнэ дарга гээд олон жил хийсэн. Манай энэ сум чинь Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны шавь нутаг.Бас хөөрхөн эрх дархтай, алба татвар энэ тэр юмнаас хөнгөлөгдөнө .Олон сумын төвлөрөл байсан. За Архангай, Хашаат, Хотонт, Булганы Гурванбулаг, Өвөрхангайн Хужирт, Лүн гээд.Тэгээд манай сум 1942 онд Архангайгаас Өвөрхангай рүү шилжсэн юм.

Жужа: Баруун хийдэд дарь эх лам гэж байсан үү?

Норжингийн Дашцэрэн: Байсан. Хүмүүс их ярьдаг байсан. Би бага байсан болоод сайн мэдэхгүй.

Жужа: Ойр орчимд тахилгат уул овоо бий юу?

Норжингийн Дашцэрэн: Түүрүүн хэлсэн, Жаргалант хайрхан уул. Ухаа овоо, Голын овоо, Шанх гээд эртнээс тахиж ирсэн уул овоо бий.

Жужа: Та багадаа ойр хавийн сүм хийдээр орж гарч байсан үү?

Норжингийн Дашцэрэн: Үгүй үгүй. Явдаггүй байсан.

Жужа: Хүүчин Төвхөн хийдийн тухай та хэр мэдэх вэ?

Норжингийн Дашцэрэн: Үгүй Төвхөн хийд бол ерөөсөө өндөр гэгээний гол өргөө байсан. Богдын ногоон ордон гэдэг шиг. Ер нь үүх, түүх хурал номын хувьд баруун хүрээтэй салшгүй холбоотой. Ер нь Гандан, Эрдэнэ зуу,

Баруун хүрээ , Төвхөн, нөгөө Сэлэнгийн Амарбаясгалан, Хэнтийн Бэрээвэн энэ хэдийг Халхын долоон том хүрээ **Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 4 хувийн мэдээллээс бүрдсэн болно.**

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гэдэг байсан юм гэнэ лээ. Бусад нь бол дандаа орон нутгийн шинжтэй хүрээ хийд. 1990 онд сайд нарын зөвлөлийн тогтоол гарч хүрээ хийд сэргээхэд энэ хэдийн нэр хамгийн түрүүнд орж байсан.

Жужа: За баярлалаа.

Норжингийн Дашцэрэн: Тэгээд л одоо манай лам нар чинь хийдийнхээ бурхан шүтээнүүдийг хадгалж байгаад л өгсөн юм. Одоо энэ найдан , махгал, очирваань, ямандаг гээд л .

Энхбаяр: Очирваань гол шүтээн биз?

Норжингийн Дашцэрэн: Тэгэлгүй яахав, манай очир шүтээн.Тэр үеийн авч үлдсэн юмнуудаас үр хүүхдэдээ өгөөгүй юмнууд байдаг юм ш дээ: Бие биендээ л дамжуулж хадгалаад байдаг байж. Ухаан нь энэ мөнгөн тоногтой бишгүүр байна. Үүнийг Хагархай гэж бөх лам хүн байж.Тэр хүн хадгалж байгаад Луузан үнзад гэдэг хүнд өгч.Тэр Луузан үнзад бол манай Гандангийн үнзад Долгорын Луузан гэдэг өвгөн.Тэгээд ерэн онд хүрээг сэргээхэд авчирч өгсөн байх жишээтэй. Наймдугаар Богдын одоо фото зураг байдаг байсныг Цэрэнбалжир гэж лам өвгөн одоо энэ генерал Дашзэвэгийн аав.Тэр өвгөн хадгалж байгаад хийдэд өгсөн байх жишээтэй. Тэгээд энэ бурхан тахил, ном судрыг чинь ийм юманд хийж газар булаад л хадгалж байж.

Жужа: За нэг юм асууя. Энд Чингисийн туг хадгалагдаж байсан гэж үнэн үү?

Норжингийн Дашцэрэн: Үнэн. Хар , цагаан хоёр туг том жижиг нийт таван туг байж.

Жужа: Яг хаана байсан юм бэ?

Норжингийн Дашцэрэн: Тэр хойно 5 модон гэр байсан. Тэнд 5 туг нэг нэгээрээ нэг нэг гэрт байсан юм гэнэ лээ. Энэ газар нутаг чинь хааны ах дүүсийн орон нутаг шүү дээ.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 5 хувийн мэдээллээс бүрдсэн болно.